

ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТЫГ НЭЭЖ ШУА-ИЙН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНИЙ ХЭЛСЭН ҮГ

Буурай хөгжилтэй орнууд даяарчлалын эрин үед түүний эерэг, нааштай талуудыг хүртэх, улс эх орныхоо хөгжилд дутагдалтай болон сул талуудаа нөхөх таатай нөхцөл бүрдээд байна. Монгол Улсын хувьд ч энэ үр ашгийг хүртэх нь чухал юм.

Өнөөдрийн энэ уулзалт маань хоёр хөрш гүрний харилцаан дахь эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд хүчтэй, эрчимтэй бодлого боловсруулах шаардлагатайн улмаас хийгдэж байна. Дэлхий нийтээрээ өндөр технологитой улс орнуудын технологийг ашиглах, байгалийн нөөц ихтэй орнуудын байгалийн баялгийг нь ашиглах, санхүүгийн их нөөцтэй орнуудаас хөрөнгө оруулалтыг татах, ингэснээрээ нийгмийн бүтээлийг дээшлүүлэх зэрэг ерөнхий чиг хандлагатай байгаа билээ. Энэ нь Монгол Улсын хувьд ч зүйтэй чиг хандлага юм. Эл утгаараа хоёр хөрш маань Монгол Улсын эдийн засгийн хөгжилд том хүчин зүйл болж байгаа нь тодорхой. ОХУ-ын хувьд эдийн засгийн бууралтаа зогсоон, эдийн засаг нь өсөлтийн чиг хандлагатай болж, Сибирь, Алс Дорнодын хөгжлийн чиг нь тодорхой болж байна. Энэ нөхцөлд ОХУ, Монгол Улсын хооронд идэвхтэй хамтын ажиллагаа үүсэх нь зайлшгүй билээ. Нэн саяхан Монгол Улсын ОХУ-д төлөх их өрийн асуудал шийдэгдсэн нь ОХУ, Монгол Улстай эрүүл саруул харилцааг хөгжүүлж, дэлхий нийтийн ерөнхий чиг хандлагатай нийцэж ажиллах эрмэлзлэлтэй байгааг харж болно.

БНХАУ-ын хувьд өнөөгийн байдлаар эдийн засаг нь маш хурдацтай хөгжиж байна. ХХI зуунд дэлхийн хамтын нийгэмлэг, соёл иргэншилд БНХАУ-ын эзлэх байр суурийг гадаадын судлаачид өндрөөр үнэлж байгаа. Ийм оронтой хамтран ажиллах, эдийн засгийн хүчин чадлаас нь өөрийн орны эдийн засгийн хөгжилд хүртээх ажил нь чухал гэдэг нь зүйн хэрэг. Одоо Монгол Улсын гадаад худалдаанд БНХАУ-ын эзлэх байр суурь өсөж байгааг бид мэднэ.

Энэ их хоёр гүрэнтэй харилцахдаа өөрийн улсын эдийн засгийн аюулгүй байдлыг харгалзан үзэх нь өнөөдөр та бидний ярилцах гол сэдэв юм. Манай ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн хоёр судлаач илтгэл бэлтгэсэн. Түүнээс гадна Монгол Улсын ГХЯ-ны Хөрш орнуудын газрын дарга О.Энхтөр, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дарга Г.Баярмагнай нар оролцож мэдээлэл хийх бөгөөд та бид уулзалтаас гарах зөвлөмжийг хэлэлцэнэ.

Өнөөдрийн бидний арга хэмжээнд хүрэлцэн ирсэн та бүхэн бидэнд үнэтэй санал өгнө гэдэгт найдаж байна. Соёл, эдийн засаг, түүх, улс төр зэрэг олон талаас нь хэлэлцэх боломж бүрэн нээгдлээ. Энэ удаагийн хуралд ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга Д.Готов гуай өөрийн биеэр ирж удирдаж байгаад ҮАБЗ-д талархаж байгаагаа энд хуран цугласан та бүгдийн нэрийн өмнөөс илэрхийлж, хурлын ажиллагааг нээснийг мэдэгдье.